

Харилцагч байгууллагуудад мэдэгдэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль шинэчилэн найруулагдан батлагдсантай холбоотой Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/249 дүгээр тушаалын хавсралт “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын тавдугаар хэсэг “Бараа, ажил, үйлчилгээний каталогийг бүртгэх”-д заасны дагуу

5.1. Аж ахуй эрхлэгч өөрийн эрхэлдэг үйл ажиллагааны хүрээнд тендер шалгаруулалтад санал болгох боломжтой бараа, ажил, үйлчилгээний дараах мэдээллийг www.tender.gov.mn цахим системд бүртгүүлнэ. Үүнд:

5.1.1. бараа ажил, үйлчилгээний шинж чанар, зориулалт;

5.1.2. барааны тэмдэг, зураг;

5.1.3. нэр, хэлбэр маяг, төрөл;

5.1.4. гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч;

5.1.5. бусад шаардлагатай мэдээлэл.

5.2. Энэ журмын 5.1-д заасан мэдээллийн бүртгэлд Нэгдсэн Үндэстний Байгууллагын стандарт бараа, үйлчилгээний код (UNSPS)-д үндэслэсэн мэргэжлийн байгууллагаас тогтоосон ангиллын кодыг баримтална.

Иймд худалдан авах ажиллагаанд оролцох сонирхолтой аж ахуй эрхлэгч нар өөрсдийн бараа, ажил, үйлчилгээний мэдээллийг цахим системд бүртгүүлсэнээр төрийн худалдан авах ажиллагаанд оролцох боломжтой болохыг мэдэгдэж байна.

МОНГОЛПРОСЦВЕТМЕТ ТӨҮГ